

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААН – Хуралдааны тойм

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААНААР ХЭЛЭЛЦСЭН АСУУДЛЫН ХӨТӨЛБӨР № 25 (ТОЙМ)

Төрийн албаны зөвлөлийн хуралдаан 2010 оны 12 дугаар сарын 29-ний өдрийн 10 цаг 30 минутанд эхэлж, 11 цаг 40 минут хүртэл Засгийн газрын Х1 байрын 301 тоот өрөөнд болж, нийт 01 цаг 10 минут үргэлжлэв.

№	Хэлэлцсэн асуудал	Гарсан шийдвэр
1	ЭМЯ-ны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтанд дүгнэлт гаргах тухай	<p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 22 дугаар зүйлийн 22.1, 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14-ийн “а”-д заасныг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2010 оны 12 дугаар сарын 29-ний өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>Эрүүл мэндийн яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын даргын албан тушаалд Сэрээнэнгийн Энхболдыг томилуулахаар дүгнэлт гарган нэр дэвшүүлж Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Хүрэлбаатарт санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
2	2010 оны 12 дугаар сарын 21-ний өдөр зохион байгуулагдсан Засгийн газрын агентлаг Цөмийн энергийн газар, Төмөр замын газрын төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөхөх зорилго бүхий төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтын дүн, “Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцөд бүртгэх, өрсөлдсөн албан тушаалд нь нэр дэвшүүлэх тухай”	<p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3, Төрийн албаны зөвлөлийн 2009 оны 63 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалт авах журам”-ын 55 дугаар зүйлийг баримталж, 2010 оны 12 дугаар сарын 21-ний өдөр зохион байгуулсан Төрийн албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн иргэдийг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэх тухай Төв комиссын саналыг хэлэлцсэн Төрийн албаны зөвлөлийн 2010 оны 12 дугаар сарын 29-ний өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>1.2010 оны 12 дугаар сарын 21-ний өдөр зохион байгуулсан төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн нэр бүхий 43 иргэнийг “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалт”-д бүртгэснийг 1 дүгээр хавсралтаар батлах,</p> <p>2.Энэхүү тогтоолын нэгдүгээр зүйлд заасан “Дэс</p>

		<p>түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалт"-д бүртгэгдсэн иргэдээс хамгийн өндөр оноо авсан нэр бүхий 18 иргэнийг тус тусын өрсөлдсөн албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлж, нэрсийг 2 дугаар хавсралтаар батлах,</p> <p>3.Энэхүү тогтоолын хоёрдугаар зүйлд заасан нэр бүхий 18 иргэнийг тухайн албан тушаалд томилохыг тус тусын томилох эрх бүхий албан тушаалтанд үүрэг болгох,</p> <p>4.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн гишүүн, Төрийн албаны мэргэшлийн шалгалтын төв комиссын дарга Д.Батбаярт даалгах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
3	<p>2010 оны 12 дугаар сарын 11, 18-ны өдрүүдэд зохион байгуулагдсан Баян-Өлгий, Увс, Өмнөговь аймгуудын нутгийн захиргааны байгууллагын төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөхөх зорилго бүхий төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтын дүн, “Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцөд бүртгэх, өрсөлдсөн албан тушаалд нь нэр дэвшүүлэх тухай”</p>	<p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3, Төрийн албаны зөвлөлийн 2009 оны 63 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалт авах журам”-ын 55 дугаар зүйлийг баримталж, 2010 оны 12 дугаар сарын 11, 18-ны өдрүүдэд Баян-Өлгий аймаг, Увс аймаг, Өмнөговь аймагт тус тус зохион байгуулсан Төрийн албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн иргэдийг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэх тухай Төв комиссын саналыг хэлэлцсэн Төрийн албаны зөвлөлийн 2010 оны 12 дугаар сарын 29-ний өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>1.2010 оны 12 дугаар сарын 11, 18-ны өдрүүдэд Баян-Өлгий аймаг, Увс аймаг, Өмнөговь аймагт тус тус зохион байгуулсан төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн нэр бүхий 6 иргэнийг “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалт”-д, нэр бүхий 71 иргэнийг “Туслах түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалт”-д бүртгэснийг 1, 2, 3 дугаар хавсралтаар батлах,</p> <p>2.Энэхүү тогтоолын нэгдүгээр зүйлд заасан “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалт”-д бүртгэгдсэн иргэдээс хамгийн өндөр оноо авсан нэр бүхий 6 иргэнийг, “Туслах түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалт”-д бүртгэгдсэн иргэдээс хамгийн өндөр оноо авсан нэр бүхий 30 иргэнийг тус тусын өрсөлдсөн албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлж, нэрсийг 4, 5, 6 дугаар хавсралтаар батлах,</p>

		<p>3.Энэхүү тогтоолын хоёрдугаар зүйлд заасан нэр бүхий 36 иргэнийг тухайн албан тушаалд томилуулахыг Баян-Өлгий аймаг, Увс аймаг, Өмнөговь аймаг дахь Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн даргад тус тус үүрэг болгох,</p> <p>4.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн гишүүн, Төрийн албаны мэргэшлийн шалгалтын төв комиссын дарга Д.Батбаярт даалгах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
4	<p>”Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэх тухай” Төрийн албаны зөвлөлийн 2010 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 133 дугаар тогтоолд өөрчлөлт оруулах тухай, “Цэрэнсамбуугийн Хишигзаяаг нөөцийн жагсаалтаас хасах, онооны дарааллыг баримтлан дараагийн иргэн болох Шонхорын Туяаг нэр дэвшүүлэх тухай”</p>	<p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3, Төрийн албаны зөвлөлийн 2009 оны 63 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийг бүрдүүлэх журам”-ын 6 дугаар зүйлийн 6.2.1 дэх хэсгийг баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2010 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн “Төрийн албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн иргэдийг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэх тухай” 133 дугаар тогтоолын 1, 2 дугаар хавсралтад өөрчлөлт оруулах тухай Төрийн албаны мэргэшлийн шалгалтын төв комиссын саналыг хэлэлцсэн Төрийн албаны зөвлөлийн 2010 оны 12 дугаар сарын 29-ний өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>1.“Төрийн албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн иргэдийг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэх тухай” 133 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын “Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн бүртгэл”-ийн “65; Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газар; Санхүү, төрийн сангийн хэлтэс; Мэргэжилтэн; Төлбөр тооцоо хариуцсан” гэсний “Цэрэнсамбуу Хишигзаяа 78.84” гэсэн хэсгийг, мөн тогтоолын 2 дугаар хавсралтын “Төрийн жинхэнэ албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлсэн иргэдийн жагсаалт”-ын “12; Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газар; Санхүү, төрийн сангийн хэлтэс; Мэргэжилтэн; Төлбөр тооцоо хариуцсан” гэсний “Цэрэнсамбуу Хишигзаяа 78.84” гэсэн хэсгийг тус тус хасах,</p> <p>2.“Төрийн албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн иргэдийг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэх тухай” 133 дугаар тогтоолын нэгдүгээр зүйлд заасан нутгийн захиргааны байгууллагын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэгдсэн иргэдээс онооны дарааллыг баримтлан Шонхорын Туяаг Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газрын Санхүү,</p>

		<p>төрийн сангийн хэлтсийн “Төлбөр тооцоо хариуцсан мэргэжилтэн”-ий албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлэх тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
5	<p>Төрийн албаны зөвлөлийн Ажлын албаны даргыг томилох тухай</p>	<p>Төрийн албаны тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.13, Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.1.4, Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм”-ийн 3.5 дахь хэсгийг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн Ажлын албаны даргын албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулсан Сонгон шалгаруулах комиссын дүгнэлтийг хэлэлцсэн Төрийн албаны зөвлөлийн 2010 оны 12 дугаар сарын 29-ний өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>Төрийн албаны зөвлөлийн Ажлын албаны даргаар Самдангийн Цэдэндамбыг 2011 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн томилох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
6	<p>Төрийн албаны зөвлөлийн 2010 онд дэвшүүлсэн зорилтын хэрэгжилт, 2011 онд дэвшүүлэх зорилтын тухай</p>	<p>Төрийн албаны зөвлөлийн 2010 онд дэвшүүлсэн зорилтын хэрэгжилт, 2011 онд дэвшүүлэх зорилтын тухай хэлэлцсэн Төрийн албаны зөвлөлийн 2010 оны 12 дугаар сарын 29-ний өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>Нэг.Төрийн албаны зөвлөл болон түүний Салбар зөвлөлүүдийн 2010 онд хийж гүйцэтгэсэн дор дурдсан 10 ажлыг ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛААР нэрлэх:</p> <p>1.Монгол Улсын төрийн албаны төв байгууллага үүсгэн байгуулагдсаны 15 жилийн ойг төрийн албаны стандартын хэрэгжилтийг хангах уриан дор бүх Салбар зөвлөлийг оролцуулан улсын хэмжээнд тэмдэглэв. Ой угтан яам, агентлаг, аймаг, нийслэл дэх Төрийн албаны зөвлөлийн 47 салбар зөвлөл төрийн албаны хууль тогтоомж, стандартыг хангах уриан дор 15 багц ажлыг төлөвлөн хэрэгжүүлж, Төрийн албаны зөвлөл тэдний хийсэн ажлын үр дүнг анх удаа тусгай аргачлалын дагуу дүгнэж, амжилт гаргасан 9 салбар зөвлөлийг шагнаж урамшуулсан нь төрийн албаны хууль тогтоомж, стандартын хэрэгжилтийг нийт төрийн албаны хэмжээнд жигд сайжруулахад мэдэгдэхүйц нөлөө үзүүлснээс гадна цаашид Салбар зөвлөлүүд ажлын чанар, үр дүнгээр өрсөлдөх жишиг тогтоолоо.</p> <p>2.Яам, агентлаг, аймаг, нийслэл, дүүрэг, бүгд 85 нэгжид төрийн жинхэнэ албаны боловсон хүчний хэрэгцээг төлөвлөх, хангалтыг зохион байгуулах</p>

	<p>ажлыг шалган зааварлаж, энэ талаарх зөрчлийг арилгах арга хэмжээ авч ажилласан нь урд өмнө байгаагүй өргөн цар хүрээтэй үйл ажиллагаа болов.</p> <p>3.Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтыг төрийн захиргааны төв, нутгийн захиргааны байгууллагуудын төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоо гарсан тухай бүр зарлан зохион байгуулдаг тогтолцоонд шилжиж, Төрийн албаны зөвлөл байгуулагдсанаас хойш хамгийн олон буюу 19 удаа сонгон шалгаруулалт явуулсан боловч түүнтэй холбогдсон ямарваа гомдол, маргаан гараагүй жил болов.</p> <p>4.Төрийн албаны зөвлөл урд нь мэргэшлийн шалгалт авах нэгдсэн стандартгүй байсан төрийн тусгай албан хаагч бүхий төрийн 10 байгууллагад төрийн тусгай албан тушаалд анх орох иргэнээс авах мэргэшлийн шалгалтын журмыг тус тус батлан мөрдүүлснээр нийт төрийн тусгай албаны хэмжээнд Төрийн албаны тухай хуульд заасны дагуу мэдлэг чадвартай боловсон хүчнийг өрсөлдүүлсэн шалгаруулж, шударгаар сонгож авах нэгдсэн стандарт бүрдэж, түүний дагуу үйл ажиллагаа нь жигдэрлээ.</p> <p>5.Төрийн албаны зөвлөл “Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийг шинэчлэн боловсруулж, Засгийн газар баталсан бөгөөд энэхүү дүрмийг хэрэгжүүлэх журмыг анх удаа Зөвлөл өөрөө батлан мөрдүүлэв. “Төрийн албаны соёл: шударга ёс, ил тод байдал, ёс зүй” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний бага хурлыг бусад байгууллагуудтай хамтран зохион байгуулсан, энэхүү бага хуралд тавьсан илтгэлүүдийг эмхтгэн ном болгон хэвлүүлж, нийтийн хүртээл болгосон зэрэг арга хэмжээнүүд нь төрийн албан хаагчдын ёс зүйн ухамсар, сахилга, хариуцлагыг дээшлүүлэхэд чиглэгдсэн цогц ажил болж чадав.</p> <p>6.Төрийн албаны зөвлөлийн Цахим хуудасны мэдээллийн багтаамжийг нэмэгдүүлэн дизайныг сайжруулж, түүнд байршуулах мэдээллийг тогтмолжуулснаар өдөрт дунджаар 700-1000 хүн ханддаг, байнгын ажиллагаатай хамгийн өргөн хэрэглээний Сайтуудын нэг боллоо.</p> <p>7.Монгол Улсын Төрийн албаны зөвлөл болон Канадын Төрийн албаны комиссын хооронд хамтран ажиллах Санамж бичиг байгуулж, ижил чиг үүрэгтэй тус хоёр байгууллагын удирдлага харилцан айлчлал хийсэн нь Төрийн албаны зөвлөлийн гадаад харилцааг бэхжүүлэхэд том алхам болсон төдийгүй төрийн албаны</p>
--	--

		<p>шинэтгэлийг хэрэгжүүлэх чиглэлээр 100 гаруй жилийн туршлагатай энэхүү байгууллагатай хамтран ажиллах суурь тавигдав.</p> <p>8.Төрийн албаны зөвлөлийн албан хаагчдад зориулан Зуслангийн газар авсан, хөнгөлөлттэй зээлийн орон сууцанд орох нөхцөл бүрдсэн, байгууллагын Хөдөлмөрийн дотоод журамд заасан урамшуулал, тусламжийн хэмжээг мэдэгдэхүйц нэмэгдүүлсэн зэрэг нийгмийн баталгааг хангахад чиглэгдсэн арга хэмжээнүүд нь манай хамт олны тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажиллах нөхцөлийг бүрдүүлж, урам зоригийг нэмсэн арга хэмжээ болов.</p> <p>9.Яам, агентлаг, аймаг, нийслэл, дүүргийн хүний нөөцийн асуудал хариуцсан 85 ажилтны 3 удаагийн 40 цагийн “Төрийн албаны стандарт, хүний нөөцийн удирдлага” сэдэвт цуврал сургалтыг явуулж, Төрийн албаны зөвлөлийн удирдлага, Ажлын албаны ажилтнууд уулзалт-ярилцлага зохион байгуулсан нь төрийн албаны хууль тогтоомж, стандартын хэрэгжилтийг анхан шатанд хэрэгжүүлэхэд ач холбогдолтой шинэлэг, үр нөлөөтэй арга хэмжээ болов.</p> <p>10.Төрийн албаны зөвлөл бүрэн бүрэлдэхүүнээрээ анх удаа орон нутагт буюу Орхон аймагт Салбар зөвлөлтэйгээ хамтран Эрдэм шинжилгээний онол-практикийн бага хурал зохион байгуулж, энэ арга хэмжээг дэмжин 7 аймагт төрийн албаны хууль тогтоомж, стандартын хэрэгжилтийн талаар онол практикийн бага хурал, зөвлөгөөнүүд зохион байгуулагдаж төрийн албаны шинэтгэлийн талаар хамгийн өргөн хүрээнд хэлэлцүүлэг явагдлаа.</p> <p>Хоёр.Төрийн албаны зөвлөлөөс 2010 оныг “Төрийн албаны стандартын хэрэгжилтийн төлөө” жил болгох уриа дэвшүүлж, Монгол Улсын төрийн албаны төв байгууллага үүсгэн байгуулагдсаны 15 жилийн ойг угтаж 15 багц ажлыг Салбар зөвлөл бүр хэрэгжүүлэх зорилт тавьж ажилласнаар төрийн захиргааны төв, нутгийн захиргааны бүх шатны байгууллагуудад төрийн албаны тухай хууль тогтоомжийн болон төрийн албаны стандартын хэрэгжилтэд мэдэгдэхүйц ахиц гарсан гэж дүгнэж, цаашид энэхүү ололтыг улам бататгаж ажиллах,</p> <p>Гурав.Төрийн албаны зөвлөлөөс 2011 оныг “Ёс зүй, хариуцлагын жил” болгох уриа дэвшүүлж, Төрийн албаны зөвлөл болон түүний Салбар зөвлөлийн үйл ажиллагааг энэхүү уриаг хэрэгжүүлэхэд чиглүүлэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Төрийн албаны</p>
--	--	---

		зөвлөлийн дарга болон Салбар зөвлөлийн дарга нарт даалгах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.